



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/429

Булган сум

**Хөгжимт жүжгийн театрын зөөврийн лед дэлгэц
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 278 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.10.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Хөгжимт жүжгийн театрын зөөврийн лед дэлгэц хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

Гишүүд: Ё.Хулан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
Ц.Ганчимэг (Орон нутгийн өмчийн газрын Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн)

О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
Ц.Мөнхгэрэл (Хөгжимт жүжгийн театрын Нягтлан бодогч)
Л.Ганбаатар (Хөгжимт жүжгийн театрын лед дэлгэц хариуцсан ажилтан)
Г.Отгонбаяр (“Эрдэнэт-Булган цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: Г.Лхагвадаш (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын Төлөвлөлт, тайлагналт, мэдээлэл технологи, цахимжилтын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Хүлээн авах тоног төхөөрөмжийг техникийн үзүүлэлт, чанарын баталгаанд хяналт тавьж, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн, хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Алдармөнх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugaг Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010595